



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/54

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6, 4.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 05 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 05 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдвар (Ковид-19)-ын Омикрон хэлбэрийн халдварын тархалт нэмэгдэж, байгаатай холбогдуулан оношлуурын нөөц бүрдүүлэх, худалдан авахад 32,000,000 (Гучин хоёр сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Түргэвчилсэн оношлуур худалдан авахад шаардлагатай 32,000,000 (Гучин хоёр сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН